



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2024/02/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Санжаажав**

Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn



## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.05.13 № 142  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус станцын эзэмшилд байдаг үйлдвэрийн болон аж ахуйн зориулалтын усан сангийн газрын талбайн хэмжээ 92,338 мкв-аар нэмэгдсэнийг ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А-1/2491 тоот “Газар эзэмших эрхийг бүртгэлд тусгах тухай” албан бичгийн дагуу Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу 1,108,056.0 мянган төгрөгөөр үнэлж санхүүгийн тайлангийн биет бус хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд 427.3 сая.кВт.ц ЦЭХ, 668.9 мян.Гкал ДЭХ боловсруулж, 368.4 сая.кВт.ц ЦЭХ, 647.4 мян.Гкал ДЭХ түгээсэн нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс ЦЭХ 21.6 хувиар, ДЭХ 47.0 хувиар тус тус өсөж, борлуулалтын орлого 15,303,882.0 мянган төгрөг буюу 28.4 хувиар нэмэгджээ.

### Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 84 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 99.9 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

000028254

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	120,752,146.97	332,930,593.94
1.1.2	Дансны авлага	2,993,461,142.84	3,343,605,873.82
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	772,516,021.61	473,679,929.71
1.1.4	Бусад авлага	254,915,666.35	191,517,408.14
1.1.6	Бараа материал	5,319,307,144.77	7,317,321,872.33
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	666,021,528.47	523,512,583.15
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>10,126,973,651.01</b>	<b>12,182,568,261.09</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	138,980,364,957.01	129,418,807,445.61
1.2.2	Биет бус хөрөнгө	24,553,601,063.35	25,288,408,451.70
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>163,533,966,020.36</b>	<b>154,707,215,897.31</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>173,660,939,671.37</b>	<b>166,889,784,158.40</b>
2.1.1.1	Дансны өглөг	7,547,826,968.41	5,136,457,500.38
2.1.1.2	Цалингийн өглөг	464,458,456.00	551,231,225.00
2.1.1.3	Татварын өр	568,266,604.10	29,068,828.06
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	1,500,000,000.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>8,580,552,028.51</b>	<b>7,216,757,553.44</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	78,843,610,402.20	80,548,254,520.77
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	3,493,125,405.57	-
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>82,336,735,807.77</b>	<b>80,548,254,520.77</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>90,917,287,836.28</b>	<b>87,765,012,074.21</b>
2.3.1	Төрийн өмч	10,040,100,005.47	10,040,100,005.47
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	71,992,043,066.58	71,884,437,391.18
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	22,603,140,000.00	23,699,196,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(21,891,631,236.96)	(26,498,961,312.46)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>82,743,651,835.09</b>	<b>79,124,772,084.19</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>173,660,939,671.37</b>	<b>166,889,784,158.40</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>53,920,465,545.64</b>	<b>69,224,347,594.06</b>
2	Борлуулалтын өртөг	58,681,888,336.90	70,763,626,393.37
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>(4,761,422,791.26)</b>	<b>(1,539,278,799.31)</b>
5	Хүүгийн орлого	-	1,102,398.61
8	Бусад орлого	10,286,025,449.74	4,321,847,307.79
10	Ерөнхий ба удирдлагын зардал	942,278,692.48	1,012,214,008.40
11	Санхүүгийн зардал	19,365,197.45	44,061,124.10
12	Бусад зардал	3,513,224,636.22	3,772,005,341.86
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	(9,342,134,976.25)	(2,571,638,632.04)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	42,989,538.26	10,228,363.67
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>(8,249,411,305.66)</b>	<b>(4,606,019,835.64)</b>
19	Орлогын татварын зардал	-	1,310,239.86
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>(8,249,411,305.82)</b>	<b>(4,607,330,075.50)</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>(8,249,411,305.82)</b>	<b>(4,607,330,075.50)</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	10,040,100,005.47	72,035,033,589.81	22,603,140,000.00	(13,167,699,931.14)	91,510,573,664.14
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	(8,249,411,305.82)	(8,249,411,305.82)
6	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	(474,520,000.00)	(474,520,000.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(42,990,523.23)	-	-	(42,990,523.23)
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	10,040,100,005.47	71,992,043,066.58	22,603,140,000.00	(21,891,631,236.96)	82,743,651,835.09
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	10,040,100,005.47	71,992,043,066.58	22,603,140,000.00	(21,891,631,236.96)	82,743,651,835.09
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
13	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	(4,607,330,075.50)	(4,607,330,075.50)
14	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	1,096,056,000.00	-	1,096,056,000.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(107,605,675.40)	-	-	(107,605,675.40)
17	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	10,040,100,005.47	71,884,437,391.18	23,699,196,000.00	(26,498,961,312.46)	79,124,772,084.19

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	51,423,996,681.43	66,310,301,184.24
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	51,045,548,950.56	65,786,770,252.96
1.1.6	Бусад мөнгөн орлого	378,447,730.87	523,530,931.28
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	49,453,702,810.62	65,449,212,127.29
1.2.1	Ажиллагчдад төлсөн	10,725,542,565.05	12,743,571,551.90
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,323,300,000.00	4,476,079,750.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	13,004,790,448.84	16,460,969,206.17
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	18,308,434,569.98	25,888,350,900.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	30,087,378.00	49,314,665.92
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	4,022,140,495.47	5,817,601,755.79
1.2.9	Бусад мөнгөн зарлага	39,407,353.28	13,324,297.51
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,970,293,870.81</b>	<b>861,089,056.95</b>
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	1,102,398.61
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	1,102,398.61
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	700,976,829.15	2,109,262,168.84
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	700,976,829.15	2,109,262,168.84
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(700,976,829.15)</b>	<b>(2,108,159,770.23)</b>
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,358,735,609.00	7,268,526,751.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,358,735,609.00	7,268,526,751.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,705,769,759.76	5,809,887,794.67
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	3,231,249,759.76	5,809,887,794.67
3.2.4	Төлсөн ногдол ашиг	474,520,000.00	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,347,034,150.76)</b>	<b>1,458,638,956.33</b>
4	Валютын ханшийн зөрүү	1,865,861.55	610,203.92
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(75,851,247.55)</b>	<b>212,178,446.97</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>196,603,394.52</b>	<b>120,752,146.97</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>120,752,146.97</b>	<b>332,930,593.94</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Хэмжих нэгж	2023		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
0	2		3	4	5	6	7
1	Боловсруулах	ЦЭХ	мян.квтц	413,941.0	427,310.8	13,369.8	103.2
		ДЭХ	мян.Гкал	646,537.0	668,919.9	22,382.9	103.5
	ДХЦЭХ	хувиар	%	14.9	13.8	(1.1)	92.7
		биетээр	мян.квтц	61,623.0	58,915.6	(2,707.4)	95.6
	Түгээх	ЦЭХ	мян.квтц	352,318.0	368,395.2	16,077.2	104.6
		ДЭХ	мян.Гкал	622,937.0	647,444.9	24,507.9	103.9
2	Нийт орлого		мян.төг	76,053,087.7	81,305,730.0	5,252,642.3	106.9
	Үүнээс :Борлуулалтын орлого		мян.төг	65,612,557.3	69,224,347.6	3,611,790.3	105.5
	үйл ажиллагааны бус орлого		мян.төг	10,440,530.4	12,081,382.4	1,640,852.0	115.7
3	Нийт зардал		мян.төг	82,803,090.8	85,911,749.7	3,108,658.9	103.8
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал		мян.төг	72,362,560.8	74,268,785.0	1,906,224.2	102.6
	Үйл ажиллагааны бус зардал		мян.төг	10,440,530.0	11,642,964.8	1,202,434.8	111.5
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		мян.төг	(6,750,003.1)	(4,606,019.8)	2,143,983.3	68.2
5	Татварын дараах ашиг /алдагдал/		мян.төг	(6,750,003.1)	(4,607,330.1)	2,142,673.0	68.3
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		мян.төг	1.10	1.07	(0.0)	97.3
7	Нийт авлага		мян.төг	3,930,900.0	4,008,803.2	77,903.2	102.0
	Үүнээс:	ЭХ-ний	мян.төг	2,993,400.0	3,343,605.9	350,205.9	111.7
		Бусад	мян.төг	937,500.0	665,197.3	(272,302.7)	71.0
8	Нийт өглөг		мян.төг	90,841,400.0	87,765,012.1	(3,076,387.9)	96.6
	Үүнээс:	Урт хугацаат өр	мян.төг	82,262,700.0	80,548,254.5	(1,714,445.5)	97.9
		Богино хугацаат өр	мян.төг	8,578,700.0	7,216,757.6	(1,361,942.5)	84.1
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	482.0	470.0	(12.0)	97.5
10	Нийт цалингийн сан		мян.төг	16,030,199.8	16,002,290.6	(27,909.2)	99.8
11	Жишмэл түлшний зарцуулалт	ЦЭХ	гр/кВтц	433.0	426.7	(6.2)	98.6
		ДЭХ	кг/Гкал	189.8	189.8	(0.0)	100.0
12	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		мян.төг	6,204,461.2	3,658,360.0	(2,546,101.2)	59.0

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 153,783.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил<sup>1</sup> илрүүлж 3 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

- Төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй болно.

### 5.2 Албан шаардлага

- Албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

- Тус станцын үндсэн хөрөнгө дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10,255,124.2 мянган төгрөгийн балансын үнэтэй 1,181 нэр төрлийн үндсэн хөрөнгө байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, компанийн НБББББ-ийн 4.4-д заасантай нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгүүдийг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн дахин үнэлгээ хийлгэж ашиглах, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийг актлах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх

#### 2. Авлага данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

- Төмөр замын ашиглалт, түрээстэй холбоотой иргэнтэй үүсгэсэн 643.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, компанийн НБББББ-ийн авлагын талаар баримтлах бодлоготой тус тус нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

- Цаашид уг алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3. Урьдчилж төлсөн зардал тооцоо данстай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

- Татвар, НДШ-ийн нийт 153,139.7 мянган төгрөгийн илүү төлөлтийг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын бүлэг 2-7, компанийн НБББББ-ийн 4.1 авлага ба урьдчилгаа төлбөрийн бүртгэл талаар баримтлах бодлоготой тус тус нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

- Цаашид уг алдаа зөрчлийг давтан гаргахгүй байж, авлага, урьдчилж төлсөн зардлыг НБББББ-т заасан ангиллын дагуу бүртгэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 11 дугаар сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Татвар, НДШ-ийн 153,139.7 мянган төгрөгийн илүү төлөлтийг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэсэн байна.	1	153,139.7			1	153,139.7			1	153,139.7	1	153,139.7
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>153,139.7</b>			<b>1</b>	<b>153,139.7</b>			<b>1</b>	<b>153,139.7</b>	<b>1</b>	<b>153,139.7</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		Тоо
Төмөр замын ашиглалт, түрээсийн авлага 643.5 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	643.5					1	643.5				
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10,255,124.2 мянган төгрөгийн балансын үнэтэй 1,181 нэр төрлийн үндсэн хөрөнгө байна.	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>643.5</b>					<b>2</b>	<b>643.5</b>				